



ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2015 оны 05 дугаар сарын 05-ны өдөр

Монголбанк нь 2015 онд Улаанбаатар хот болон орон нутгийн хэмжээнд иргэд, аж ахуйн нэгжүүдээс түүвэр судалгаа авах, дараах 2 ажлыг хийж гүйцэтгэх судалгааны байгууллагыг сонгон шалгаруулна.

Ажил 1: “Бизнесийн түүвэр судалгаа”

Судалгааны хамрах хүрээ	Судалгааны объект	Түүврийн хэмжээ	Давтамж	Судалгааг гүйцэтгэх хугацаа	Гүйцэтгэх ажил
Улаанбаатар хот /9 дүүрэг/ болон Төв аймаг	Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид	1050	Жилд 1 удаа	2015 оны I хагас	Түүвэр судалгаа авах, санал асуулгыг тусгай програмд шивж оруулах, өгөгдөл бэлтгэх
Орон нутаг /20 аймаг/	Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид	800	Жилд 1 удаа	2015 оны I хагас	Монголбанкны орон нутаг дахь салбаруудын авсан санал асуулгыг тусгай програмд шивж оруулах, өгөгдөл бэлтгэх

Ажил 2: “Эдийн засгийн түүвэр судалгаа”

Судалгааны хамрах хүрээ	Судалгааны объект	Түүврийн хэмжээ	Давтамж	Судалгааг гүйцэтгэх хугацаа	Гүйцэтгэх ажил
Улаанбаатар хот /9 дүүрэг/ болон Төв аймаг	Иргэд	1100	Жилд 1 удаа	2015 оны II хагас	Түүвэр судалгаа авах, санал асуулгыг тусгай програмд шивж оруулах, өгөгдөл бэлтгэх
Орон нутаг /20 аймаг/	Иргэд	1700	Жилд 1 удаа	2015 оны II хагас	Монголбанкны орон нутаг дахь салбаруудын авсан санал асуулгыг тусгай програмд шивж оруулах, өгөгдөл бэлтгэх

Бүрдүүлэх материал:

1. Компаний туршлага, ашиглаж буй програм хангамж болон боловсон хүчний ур чадварын талаарх товч танилцуулга /2 нүүрээс хэтрэхгүй/
2. Нотариатаар баталгаажуулсан аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /1 хувь/
3. Түүвэр судалгаа явуулах үнийн санал /судалгааны ажил тус бүр дээр/

Түүвэр судалгааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг **(976) 11-322104** утаснаас лавлана уу.

Үнийн санал болон бусад материалыг доорх хаягаар 2015 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 16⁰⁰ – цагаас өмнө ирүүлнэ үү.

**Бага тойруу 3, 15160, Улаанбаатар, Монголбанкны “А” байр,
Мөнгөний бодлого, судалгааны газар, Судалгааны хэлтэс
МОНГОЛБАНК**